



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# Шүүхийн иргэдийн төлөөлөгч (гарын авлага)

Улаанбаатар  
2015 он

DDC  
347'023  
T-727

Зохиогч:

Н.ТУЯА

МУИС-ын ХЭС-ийн Практик  
сургалтын тэнхимийн эрхлэгч,  
Шүүхийн ерөнхий зөвлөл

Зураач:

О.ТОДБАЯР

Хянан тохиолдуулсан:

П.БАДАМАРГЧАА

Нээлттэй Нийгэм Форумын  
Засаглалын хөтөлбөрийн менежер

Ц.СОЁЛМАА

ШЕЗ-ийн Шүүхийн Иргэдийн  
телөөлөгчийн асуудал хариуцсан  
референт

Д.МОНГОНТУУЛ

ШЕЗ-ийн Бодлогын асуудал хариуцсан  
референт

С.ЭНХБАЯР

ШЕЗ-ийн Шүүхийн захиргааны  
хэлтсийн дарга, Шүүхийн захиргааны  
удирдлагын газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

*Энэхүү гарын авлагыг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр  
бэлтгэж хэвлэв.*

ISBN 978-99973-0-529-9

© Зохиогчийн эрх: Н.Туяа ба Шүүхийн ерөнхий зөвлөл

## ӨМНӨХ ҮГ

Юуны өмнө шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохоор сонгогдсон Танд баяр хүргэе. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан шүүхийн шинэтгэл, түүний хүрээнд батлагдсан Шүүхийн тухай багц хуулийн нэг болох Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлж байна. Энэ хууль бодитоор хэрэгжихэд иргэн таны идэвх, санаачилга, үүрэг оролцоо, дуу хоолой нэн чухал шаардлагатай билээ.

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож, таны дуу хоолой шүүхэд хүрснээр таны эрх зүйн мэдлэг дээшлэхээс гадна шүүн таслах ажиллагаанд иргэдийн оролцоо, хяналтыг бий болгох, шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй болох, улмаар иргэдийн итгэлийг хүлээсэн үр нөлөөтэй, хариуцлагатай шүүхийн тогтолцоо бүрдэхийн зэрэгцээ шударга ёсыг тогтооход ихээхэн ач холбогдолтой юм.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч гэдэг ойлголт нь цоо шинэ зүйл биш бөгөөд өмнө нь анхан шатны шүүхэд цөөн тооны иргэдийн төлөөлөгч энэ ажлыг тогтмол гүйцэтгэсээр ирсэн. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийт хэрэгжүүлж эхэлснээр дээрх хуучин тогтолцоог халж, олон нийт, иргэн хуулиар олгогдсон энэхүү эрхээ эдлэхийн зэрэгцээ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломж, нөхцөл бүрдэнэ.

Шүүхийн шинэчлэл нь таны оролцоноос ихээхэн хамаарах тул сонгогдсон шүүх хуралдаанд идэвхтэй, хариуцлагатай оролцоорой. Танд амжилт хүсье.


Хүндэтгэсэн,  
Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх  
нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан (Ph.D)

## ТА ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР СОНГОГДЛОО

I БУЛЭГ

### 1. Шүүхийн иргэдийн төлөөлөгч гэж хэн бэ?

Та эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүх хуралдаанд тухайн шүүхийн харьяллын нутаг дэвсгэрт амьдран сууж буй нийт иргэдийг төлөөлөн оролцох “Шүүхийн иргэдийн төлөөлөгч”-ийн хариуцлагатай ажилд сонгогдоо. Юуны өмнө танд “Шүүхийн иргэдийн төлөөлөгч” гэж хэн болох тухай товч тайлбарлая.



Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 05 дугаар сарын 27-ны өдөр шүүх эрх мэдлийн шинэчлэлийн ажлын хүрээнд Шүүхийн тухай багц хуулиудыг баталсны нэг нь “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль” юм. Энэ хуулиар шүүх засаглал дахь нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүх хуралдаанд иргэдийн төлөөллийг оролцуулах, тэдний санаа бодлыг сонсох зорилгоор эрх зүйн хэрэг маргааныг анхан шатны журмаар, гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах, түүнтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч гэж анхан шатны шүүхээр эрүүгийн, иргэний болон захиргааны

хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэд, олон нийтийг төлөөлөн оролцохоор сонгогдсон Монгол Улсын иргэнийг ойлгоно. Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцохдоо идэвхгүй, хариуцлагагүй “ажиглагч”-ийн байр сууринаас бус, тухайн хэргийн үйл баримт, шүүгдэгч буюу зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлт өгөх шүүх хуралдааны оролцогч болдоороо онцлогтой юм.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох нь шүүх хуралдаанд оролцож байх байнгын ажил үүрэг биш. Та зөвхөн тухайн тохиолдлыг шийдвэрлэх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх үүрэгтэйгээр оролцоно. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу иргэн Та жилд нэг удаа л шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдоно.

## 2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид

### тавигдах шаардлага

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах иргэнд тавигдах шаардлагыг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой заасан байдал. Үүнд:

Монгол Улсын  
иргэн байх

25 нас хүрсэн байх

Эрх зүйн бүрэн  
чадамжтай байх

Ял шийтгүүлж  
байгаагүй байх

Монгол хэлээр  
чөлөөтэй ярьж,  
ойлгодог байх



Тухайн анхан шатны  
шүүхийн харьяалын  
нутаг дэвсгэрт байнга  
оршин суудаг байх

Сонгогдох үедээ  
эрүүгийн байцаан  
шийтгэх, иргэний  
болон захиргааны  
хэрэг хянан  
шийдвэрлэх  
ажиллагааны хэргийн  
оролцогч бус байх

Сүүлийн нэг жилийн  
хугацаанд иргэдийн  
төлөөлөгчөөр  
шүүх хуралдаанд  
оролцоогүй байх

### **3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулалт**

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох шаардлага хангасан иргэдээс тухайн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох иргэнийг сонгох ажиллагааг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн баталсан журмаар тодорхой зохицуулсан байдал.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана. Ингэхдээ эхлээд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах боломжтой иргэдийн нэрийг тухайн нутаг дэвсгэрийн сонгогчдын нэрийн жагсаалтаас гаргана.

Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрийн жагсаалтад нэр нь орсон иргэнийг иргэдийн төлөөлөгчийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, мэдээллийн сан бүрдүүлнэ. Иргэдийн төлөөлөгчийн нэрийн нэгдсэн жагсаалтыг Шүүхийн ерөнхий зөвлөл баталж, цахим програмд нэrsийг байршуулна. Баталсан иргэдийн төлөөлөгчийн жагсаалтаас шүүхийн тамгын газар хуралдаанд оролцуулах, иргэний төлөөллөгчийг сонгох ажлыг зохион байгуулна. Нэрийн нэгдсэн жагсаалтаас тухайн долоо хоногт шүүх хуралдаанд оролцох 10-15 иргэнийг тусгай програмын тусламжтайгаар, санамсаргүй аргаар сонгож дэд жагсаалт бүрдүүлнэ. Тухайн долоо хоногийн шүүх хуралдааны тов гарсны дараа дэд жагсаалтад орсон иргэдээс шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох иргэнийг сугалааны журмаар сонгодог. Энэхүү “тохиолдлын” зарчимд суурилсан сонгон шалгаруулах ажиллагааны үр дүнд тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчөөр Та сонгогдсон байна. Сонгон шалгаруулахдаа үндэс угсаа,

арысны өнгө, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, боловсролоор ялгаварлан гадуурхахыг хориглоно.

## Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгох ажиллагааны үе шат

1

Тухайн нутаг дэвсгэрийн сонгогчдын нэрийн жагсаалтаас шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох хууль зүйн шаардлага хангасан иргэдийн нэрийн цахим жагсаалт гаргана.

2

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцох боломжтой иргэдийн нэрийн цахим жагсаалтаас тухайн долоо хоногт шүүх хуралдаанд оролцох 10-15 иргэнийг тусгай програмын тусламжтайгаар сонгож, дэд жагсаалт гаргана.

3

Тухайн долоо хоногийн хуралдааны тов гарсны дараа тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийг сугалааны журмаар тодруулна.

### 4. Шүүхийн мэдэгдэх хуудас

Иргэдийн эрх зүйн мэдлэг дутмаг байдалтай холбоотойгоор “Шүүх” гэдэг үгийг сонсмогц ямар нэгэн таагүй, сөрөг сэтгэгдэл төрөх, шүүх ажиллагаананд ямар нэг хэлбэрээр оролцохоос айх, төвөгшөөх, түүнээс аль болох хол байхыг хүсэх зэрэг буруу ойлголт түгээмэл байдаг. Эрх зүйт нийгэмд амьдарч буй иргэн та хэний ч зөрчигдсөн эрхээ хамгаалуулах шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцож магадгүй учраас санаа зовох, цэрвэх шаардлагагүй.

Шүүхийн мэдэгдэх хуудас гэдэг нь таныг шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хувиар шүүх хуралдаанд орохоор сонгогдсоныг албан ёсоор мэдэгдэж буй мэдэгдэл юм.

Та шүүхийн мэдэгдэх хуудас хүлээн авснаар энэхүү үнэт цагийг ашиглан танд хуулийн мэдэгээ дээшлүүлэх боломж нээгдэх юм. Мэдэгдэлд таны оролцох шүүх хуралдааны огноо, цагийг заасан байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон тухай мэдэгдэх хуудсыг танд биечлэн гардуулж, гарын үсэг зуруулдаг. Хэрэв тодорхой шалтгааны улмаас биечлэн гардуулах боломжгүй тохиолдолд энэ тухай утсаар мэдэгдэж болно. Утсаар мэдэгдсэн тохиолдолд мэдэгдэх хуудсыг биечлэн хүлээн авсантай нэгэн адил тооцогдох учир хариуцлагатай, анхааралтай хандаж, шүүх хуралдааны товыг сайтар лавлах нь зүйтэй.



Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд энэ тухай мэдэгдлийг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгддэг. Ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэж байгаа нь танд шүүх хуралдаанд оролцохын тулд хувийн болон албан ажлаа зохицуулах, шүүх хуралдаанд бэлтгэх боломжийг олгох зорилготой болно.

Та шүүх хуралдаанд оролцох тухай мэдэгдэх хуудас хүлээн авснаар хуралдаанд оролцох боломжтой эсэхээ сайтар няглан үзэж, нухацтай хандах нь зүйтэй. Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн нь зөвхөн хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаан байгаа тохиолдолд л шүүх хуралдаанд оролцохоос чөлөөлөгдөх боломжтой. Хэрэв Та хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа шүүхийн тамгын газарт нэн даруй мэдэгдэх ёстойг анхаарна уу.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар дараах тохиолдлыг хүндэтгэн үзэх шалтгаанд тооцно.

1. Эмнэлгийн магадлааар баталгаажсан эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон.




2. Ажил олгогчийн баталгаажуулсан албан томилолттой байсан.

3. Бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бөгөөд энэ талаар хорооны Засаг даргын тодорхойлолттой.



4. Хүндэтгэн үзэх бусад шалтгаантай (хөл хорионд орсон, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд орсон зэрэг).



### 5. Та өөрийн эрхэлдэг ажлаа хэрхэн зохицуулах вэ?

Та шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохоор сонгогдсон тухай мэдэгдэх хуудас хүлээн авмагц хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол хуралдаанд оролцох боломжтой тухайгаа шүүхийн тамгын газарт мэдэгдэнэ. Ингэснээр шүүхийн тамгын газраас таны ажил олгогчид шүүх хуралдааны өмнө энэ талаар мэдэгдэл хүргүүлдэг учир Та “ажил таслах болох нь” гэж санаа зовох шаардлагагүй.

Ажил олгогч тань шүүхийн тамгын газрын мэдэгдлийг хүлээн авснаар иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээдэг. Хэрэв ажил олгогч нь энэ үүргээ зөрчиж, иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон ажилтанд чөлөө өгөхгүй байх, шүүх хуралдаанд оролцох боломжкоор хангаагүй тохиолдоод Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хариуцлага болох нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн

торгууль төлнө. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 07 дугаар тогтоод заасны дагуу нэг сарын хөдөлмөрийн хөлсийг 192.000 төгрөг байхаар тогтоосон болно.

## ТА ШҮҮХ ХУРАЛДААНД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

### 1. Шүүх хуралдаанаас өмнө хэргийн материалтай танилцах



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудаар иргэдийн төлөөлөгч танд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх эрх олгогдсон. Хэргийн материалтай танилцах эрх нь танд мэдэгдэх хуудас очсоноос хойш үүсэх юм. Хэргийн материалтай танилцах нь Та шүүгдэгч, зохицчийн гэм буруугийн талаар мэдээлэлтэй болж, шүүх хуралдаан дээр тэдний мэтгэлцээнийг сонсож, харьцуулан өөрийн дүгнэлтээ гаргахад ач холбогдолтой.

### 2. Та шүүх хуралдаанд юу авч очих шаардлагатай вэ?

Та шүүх хуралдаанд ирэхдээ шүүхийн мэдэгдэх хуудас болон иргэний үнэмлэхээ заавал авчирна. Хэрэв иргэний үнэмлэхээ хаяж, гээгдүүлсэн болон сунгалт хийлгүүлэхээр Улсын бүртгэлийн албан дөгсөн байгаа зэрэг шалтгаанаар таны иргэний үнэмлэх байхгүй тохиолдолд харьяа дүүргийнхээ Иргэний бүртгэлийн албанаас болон ТҮК машинаас иргэний үнэмлэхийн лавлагаа авчрах шаардлагатай.

Харин шүүх хуралдааны үеэр гар утас хэрэглэх, ном сонин уншихыг хориглоно.



### 3. Та шүүх хуралдааны өдөр хэрхэн хувцаслах вэ?

Ер нь шүүх хуралдааны хувцаслалтын дүрэм гэж байхгүй. Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь хэдийгээр шүүх хуралдааны оролцогч боловч тусгайлсан өмсгөл өмсдөггүй. Түүнчлэн иргэдийн төлөөлөгч нь костюм, зангиа, юбка зэрэг ёслолын хувцас заавал өмсөх албагүй. Ерөнхийдөө өөрт эвтэйхэн байдлаар хувцаслах нь зүйтэй. Гэхдээ биеийн ихэнх хэсэг ил гарсан буюу хэт задгай, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг сурталчилсан үг хэллэг, дүрс, зураг бүхий хувцас өмсөх нь зохимжгүй болохыг анхаарна уу. Таны хувцаслалт шүүх болон шүүх ажиллагааг хэрхэн хүндэтгэж буйг тань илэрхийлнэ.



## ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОВЛОСОН ӨДӨР ИРЛЭЭ

- 1. Та шүүх хуралдаанаас ямар хугацааны өмнө шүүхийн байранд ирэх ёстой вэ?**

Та шүүх хуралдаан болох цагаас доод тал нь нэг цагийн өмнө ирсэн байх ёстой. Шүүх хуралдаан болох цагийг тулгаж ирснээр хуралдаанаас өмнө хийгдэх ёстой ажлууд амжихгүй болох, ингэснээр шүүх хуралдаан товлосон цагаасаа хоцрох, хойшлогдох зэрэг олон сөрөг үр дагаварт



хүргэж болзошгүй тул Та замын хөдөлгөөний ачаалал, түгжрэл зэргийг сайтар тооцож, цагаа зөв төлөвлөнө үү.

- 2. Та шүүхийн байранд ирээд хэнтэй уулзах ёстой вэ?**

Та шүүхийн байранд ирээд шүүхийн тахрын ажилтантай уулзаж, шүүхийн мэдэгдэх хуудас, иргэний үнэмлэхээ үзүүлнэ. Үүний дараа

шүүхийн тахрын ажилтан таныг шүүхийн тамгын газрын ажилтантай уулзуулна. Шүүхийн тамгын газрын ажилтан нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийг тусгайлан бэлтгэсэн өрөөнд байлгаж, холбогдох бэлтгэл ажлыг хангана.

### **3. Шүүх хуралдаан эхлэхээс өмнө мэдэж авах, анхаарах зүйлс**

Та шүүх хуралдаан эхлэхээс өмнө өөрийн эддэх эрх, хүлээх үүрэг, түүнчлэн шүүх хуралдааны дэгийн талаар мэдэх шаардлагатай. Энэ талаарх мэдээллийг Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн шүүх хуралдаан болохоос өмнө танилцуулна.

Мөн дээрх мэдээллийг гарын авлага унших, богино видео хичээл үзэх зэрэг хэлбэрээр авч болно. Эдгээр мэдээлэл нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn) цахим хуудаснаа тавигдсан байх бөгөөд Та мэдэгдэх хуудас авсны дараа энэхүү цахим хуудаснаас шаардлагатай мэдээллийг цаг гарган судлах хэрэгтэй.


Шүүх хуралдааны дэгийн дагуу хуралдаан эхлэхээс өмнө гар утсаа заавал унтраах шаардлагатай. Түүнчлэн шүүх хуралдааны тасралтгүй явагдах зарчмыг хангах үүднээс хуралдаан эхлэхээс өмнө хооллох, бие засах, шаардлагатай бол утсаар ярих зэргээр хувийн бэлтгэлээ сайтар хангах нь зүйтэй. Шүүх хуралдаан удаан хугацаагаар үргэлжлэх тохиолдод даргалагч шүүгчийн зөвшөөрлөөр завсарлага авч хооллох, түр гаргах боломжтой.

Та тухайн хэргийн оролцож нартай ашиг сонирхлын аливаа зөрчилгүй гэдгээ урьдчилан мэдэх ёстай. Ашиг сонирхлын зөрчлийг шүүхийн тамгын газраас гаргаж өгөх тусгай маягтын дагуу мэдэгдэнэ. Ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдод тухайн шүүх хуралдаанд оролцож болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

#### 4. Шүүх хуралдааны нийтлэг дэг

Та эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны алинд ч шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сууж болно. Эдгээр гурван хуралдаан нь тус тусын хуулиар зохицуулагдсан шүүх хуралдааны дэг, үйл явцын дагуу явагддаг хэдий ч дараах нийтлэг дэгийг баримтадаг. Үүнд:

1. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг танхимд орж ирэхэд хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босож шүүхэд хүндэтгэл үзүүлнэ.
2. Шүүх хуралдаанд оролцогчид шүүхэд хандаж мэдүүлэг өгөх, үг хэлэхдээ суудлаасаа босно.
3. Шүүх хуралдаанд оролцогч нь хүндэтгэх шалтгаантай бол хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.
4. Шүүх хуралдаанд оролцогч болон шүүх хуралдааны танхимд байгаа бусад иргэн шүүх хуралдааны дэг сахих талаар хуралдаан даргалагчаас гаргасан шийдвэрт захирагдана.
5. Насанд хүрээгүй этгээдийг шүүх дуудаагүй бол шүүх хуралдаанд оруулахгүй.
6. Үлсын яллагч, өмгөөлөгч, бусад оролцогч шүүхийн шийдвэр уншиж сонсгоход байлцана.



## ТА ШҮҮХ ХУРАЛДААНД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

### 1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тангараг

IV БҮЛЭГ

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох явдал нь шүүхэд хандах олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхээр хэрэг, маргааныг хянан хэлэлцэх ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүх шийдвэр гаргахдаа иргэдэд алагчлалгүй, тэгш хандах хуулийг баримтлах зарчмыг хэрэгжүүлэхэд иргэн таны оруулж буй хувь нэмэр мөн.

Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч танд хуулиар олгогдсон бүрэн эрхийн нэг нь шүүх хуралдаан эхлэхээс өмнө тангараг өргөх ажиллагаа юм.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаан эхлэхээс өмнө хуралдааны танхимд Монгол Улсын төрийн сүлдэнд тангараг өргөнө.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь тангараг өргөхдөө “*Иргэдийн төлөөлөгч би хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг маргааны талаар хэнээс и хараат бусаар дүгнэлт гаргахаа батлан тангараглая. Миний бие өргөсөн тангарагаа зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ.*” гэсэн тангаргийн үгийг тод чанга дуудаж, Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёсолдог. Дараа нь урьдчилан бэлтгэсэн тангаргийн хуудсыг бөглөж, гарын үсэг зурна. Таны бөглөсөн тангаргийн хуудсыг хавтаст хэрэгт хавсаргана.

Таныг тангараг өргөх үед шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдааны оролцогчид, танхимд байгаа хүмүүс бүгд босож хүндэтгэл үзүүлнэ.

Тангараг өргөх ажиллагаа нь шүүхийн иргэдийн төлөөлөгч хүн шударга ёс, хуулийг дээдлэн хараат бус байх, өргөсөн тангаргаа зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээх учрыг илтгэн төрийн сүлдэндээ андгайлж буй хүндэтгэлийн арга хэмжээ юм.

## 2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг татгалzan гаргах

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн Та эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд ямар нэг хувийн ашиг сонирхолгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилгүй оролцох нөхцлийг бүрдүүлэхийн тулд шүүх хуралдааны оролцогчдод уг хуралдаанаас сайн дураараа татгалzan гарахыг хуулиар үүрэг болгосон байдаг. Та хэргийн оролцогчидтой төрөл садан, гэр бүлийн харилцаатай, хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нөлөөлөх хувийн ашиг сонирхол байгаа тохиолдолд уг шүүх хуралдаанд оролцохоос өөрөө, сайн дураараа татгалzan гарах ёстой. Эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаас Та өөрөө сайн дураараа татгалzan гаралгүй тохиолдолд шүүх хуралдааны бусад оролцогч таныг татгалzan гаргах тухай үндэслэл бүхий хүсэлтээ гаргах эрхтэй.

Ямар шалтгааны улмаас шүүхийн иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах ёстой вэ?

1. Үрьд нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;
2. Шүүгч болон шүүх хуралдаанд оролцогчтой гэр бүлийн болон садан төрлийн холбоотой бол;
3. Гэмт хэргийн гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн хувиар хэрэгт оролцож байгаа бол.

Дараах албан тушаалын хүмүүс таныг иргэдийн төлөөлөгчөөр оролцуулахаас татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй. Үүнд:

1. Үлсын яллагч
2. Өмгөөлөгч
3. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч
4. Хохирогч, түүний өмгөөлөгч
5. Иргэний нэхэмжлэгч
6. Иргэний хариуцагч
7. Иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн хууль ёсны төлөөлөгч
8. Гуравдагч этгээд.

Таныг татгалзан гаргах тухай хүсэлтийг сонсоод үндэслэлтэй эсэх талаар Та тайлбар өгч болно. Татгалзан гаргах тухай хүсэлтийг хангах эсэхийг шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчид зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж тогтоол гаргаж шийдвэрлэнэ.

Таныг татгалзан гаргах хүсэлтийг хэдийд гаргах боломжтойг сайн мэдэж байх нь чухал юм. Хуульд зааснаар иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах хүсэлтийг гаргах эрх бүхий оролцогчид нь энэ тухай хүсэлтээ шүүх хуралдаан эхлэхээс өмнө гаргана. Гэвч татгалзан гаргах үндэслэл шүүх хуралдааны явцад тогтоогдвол тухайн үед шүүх хуралдаан даргалагчид мэдэгдэх үүрэгтэй.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргаж буй хүсэлт нь үндэслэлтэй, бодитой байх ёстой. Жишээбэл ердийн танил, хөрш зэргэлдээ амьдардаг, хамт нэг сургуульд суралцаж байсан, нэг байгууллагад хамт ажиллаж байсан хүн бүрийг иргэдийн төлөөлөгчтэй хувийн харилцаатай байсан хэмээн хавтгайруулж болохгүй. Татгалзан гаргах тухай хүсэлтийн загварыг энэхүү гарын авлагын Хавсралт хэсгээс харна уу.

Татгалзан гаргах саналыг шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн дэмжиж тогтоол гаргасан тохиолдолд Та шүүх хуралдааны танхимаас гарах үүрэгтэй бөгөөд таны оронд өөр иргэдийн төлөөлөгчийг оруулна.

### **3. Иргэдийн төлөөлөгчийн оролцох шүүх хуралдааны төрлүүд**

Хэрэг, маргааныг шүүгч дангаараа хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцохгүй. Ямар хэргүүдийг шүүгч дангаар шийдвэрлэдэг болохыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тодорхой заасан байдаг.

Шүүх бүрэлдэхүүн гэдэг нь анхан шатны шүүхэд даргалагч шүүгч, өөр хоёр шүүгчтэй хамтдаа хэрэг, маргааныг хянан хэлэлцэхийг хэлнэ.

## Шүүгч дангаар болон шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэргүүд

Анхан шатны журмаар	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Захиргааны хэрэг
Шүүгч дангаар шийдвэрлэх хэргүүд	Хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг	Хөдөлмөр, гэр бүл, тэтгэвэр, тэтгэмж, хялбаршуулсан болон онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд	Дор нэрлэнээс бусад бүх захиргааны хэрэг маргаан
Шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хэргүүд	Хүнд, онц хүнд гэмт хэрэг	Дээр нэрлэнээс бусад бүх хэрэг	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын яамнаас гаргасан захиргааны акттай холбоотой маргаан, Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан захиргааны акттай холбоотой маргаан, Шүүгч дангаар шийдвэрлэсэн шийдвэрийт давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болгосон маргаан

### 4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн шүүхийн хэлэлцүүлгийн үеэр эдлэх нийтлэг эрх

Судалгаанаас харахад Нийслэл дэх анхан шатны шүүхүүдэд иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдааны танхимд унтах, юм идэх, бохь зажлах, орж гарах, хэт хайхрамжгүй, хариуцлагагүй хандах зэрэг зөрчлүүд нэлээд түгээмэл ажиглагдаж байжээ. Иймд шүүхийг үл хүндэтгэсэн дээрх зохисгүй байдлыг гаргахгүй байж, дараах нийтлэг эрхийг үр дүнтэй хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

1. Шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, тэмдэглэл хөтлөх;
  2. Шүүгдэгч, гэрч, шинжээч, өмгөөлөгч, гуравдагч этгээд, зохигчдод асуулт тавих;
  3. Нотлох баримт шинжлэхэд оролцох;
  4. Хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруутгийн талаар бичгээр дүгнэлт гаргах;
  5. Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх.
- 5. Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны онцлог, эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо**

*A) Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны оролцогчид*

- *Улсын яллагч:* Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцож буй прокурорыг хэлнэ. Улсын яллагч нь хууль болон хангалттай нотлох баримтад тулгуурласан өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон шүүгдэгчийн гэм бурууг шүүхийн өмнө нотлох үүрэг хүлээнэ.
- *Шүүгдэгч, түүний өмгөөлөгч:* Тухайн эрүүгийн хэрэгт прокурорын яллах дүгнэлтээр буруутгагдан гэм буруугаа шүүхийн өмнө таслан шийдвэрлүүлэхээр ирсэн этгээдийг хэлнэ. Шүүгдэгчийн эрх ашгийг хамгаалахаар түүнтэй харилцан тохиролцож гэрээ байгуулсны үндсэн дээр эрх зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлжк байгаа шүүхэд төлөөлөх эрх бүхий иргэнийг түүний өмгөөлөгч гэнэ. Шүүгдэгч нь төлбөрийн чадваргүй бол төрөөс улсын өмгөөлөгч томилж болно.
- *Хохирогчийн өмгөөлөгч:* Хохирогчийн эрх ашгийг

шүүхэд төлөөлөх эрх бүхий өмгөөлөгчийг хэлнэ.

- *Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч:* Хохирогчийн төрсөн болон үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг түүний хууль ёсны төлөөлөгч гэж үзнэ.
- *Гэрч:* Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тухайн хэрэгт холбогдолгүй хүнийг хэлнэ.
- *Шинжээч:* Тухайн хэрэгт хамааралтай асуудлаар шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулахын тудь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоолоор, шүүгчийн захирамжаар томилогдсон зохих байгууллагын шинжээч, тусгай мэдлэг бүхий, тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээдийг хэлнэ.
- *Орчуулагч, хэлмэрч:* Шүүх хуралдаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй бол өөрийн эх хэл буюу мэддэг хэл, бичгээр, хараагүй, хэлгүй, дүлий этгээд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх, гомдол гаргах, шүүх хуралдаанд үг хэлэх, хэргийн холбогдох бүх материалтай бүрэн танилцах эрхээр хангагдах бөгөөд шүүхийн бүртгэлд бүртгэгдсэн мэргэжлийн орчуулагч хэлмэрчийг хэлнэ.
- *Иргэний нэхэмжлэгч, хариуцагч:* Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэх бөгөөд дээр дурдсан хохирлыг хариуцвал зохих этгээдийг иргэний хариуцагч гэнэ.

## *Б) Эрүүтийн хэргийн шүүх хуралдааны зарчим*

- Гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээд бүрт зохих ялыг шударгаар оногдуулах;

- Хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцохгүй байх;
- Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах;
- Шүүх хуралдааныг нээлттэй явуулах;
- Хэргийг шүүх хуралдаанд хэлэлцэж байхад шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй байх;
- Шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах;
- Шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх эрхийг хангах;
- Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох.

*B) Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг*

Эрүүгийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавьж болох бөгөөд шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргаж, саналаа шүүх хуралдаанд уншиж сонсгох үүрэгтэй. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид өөр хоорондоо санал зөрвөл саналаа тус тусд нь гаргаж болно.

## **6. Иргэний хэргийн шүүх хуралдааны онцлог, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо**

*A) Иргэний хэргийн шүүх хуралдааны оролцогчид*

- *Зохигч:* Нэхэмжлэгч, хариуцагч болон хуульд заасны дагуу тэдэнтэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээдийг хэлнэ.
- *Нэхэмжлэгч:* Хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ.

- *Хариуцагч*: Нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлд дурдсан этгээдийг хэлнэ.
- *Гуравдагч этгээд*: Маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргасан этгээдийг хэлнэ.
- *Өмгөөлөгч*: Гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийг төлөөлөхдөө төлөөлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульд заасан бүх арга хэмжээ авах ба шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэргийн бодит байдлыг тогтооход туслах үүрэгтэй мэргэжлийн хуульчийг хэлнэ.
- *Итгэмжлэгдсэн төлөөлөгч*: Иргэн өөрийгөө сайн дурын үндсэн дээр бусдаар, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болох бөгөөд энэхүү төлөөлөл нь итгэмжлэлээр баталгаажна.
- *Гэрч*: Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг мэдэж байгаа хэн ч гэрч байж болно.
- *Шинжээч*: Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, too бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн санаачилгаар шүүгч захирамж гарган томилогдсон иргэнийг хэлнэ.

#### *Б) Иргэний хэргийн шүүх хуралдааны зарчим*

- Шүүхийн өмнө талууд эрх тэгш байх;
- Шүүх хуралдааныг Монгол хэлээр тасралтгүй, нээлттэй явуулах;
- Талууд өмгөөлүүлэх эрхээр хангагдах;
- Хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх;
- Талууд шүүхийн өмнө мэтгэлцэх;

- Талууд нотлох баримт цуглуулах, гаргах;
- Үндэслэл бүхий шүүхийн шийдвэр гаргаж, уншиж сонсгох.

*В) Иргэний хэргийн шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үрэг*

Шүүхийн хэлэлцүүлгийн үед зохигч, гуравдагч этгээд, тэдний төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих, шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх, хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруутгийн талаар бичгээр дүгнэлт гаргах, дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

## **7. Захиргааны хэргийн шүүх хуралдааны онцлог, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо**

- А) Захиргааны хэргийн шүүх хуралдааны оролцогчид*
- *Нэхэмжлэгч:* Захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж өргөдөл гаргасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.
  - *Хариуцагч:* Захиргааны хууль бус акт гаргаж, нэхэмжлэгчийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн гэж нэхэмжлэдд дурдсан захиргааны байгууллага, албан тушаалтныг хэлнэ.
  - *Гуравдагч этгээд:* Бусад иргэн, хуулийн этгээдээс гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүх дээр үүсгэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.
  - *Прокурор:* Прокурор шүүх хуралдаанд төрийг

төлөөлж оролцох бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлийн талаар дүгнэлт гаргана.

*Б) Захиргааны хэргийн шүүх хуралдааны онцлог*

- Иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус хэмээн үзэж зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийн шүүх хуралдаан явагддаг.
- Захиргааны хэргийн шүүх хуралдааны өмнө ут захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа заавал хийгдсэн байх ёстой.
- Захиргааны хэргийн шүүхээс гаргах акт нь шийдвэр, магадлал, шүүгчийн захирамж, шийтгэвэр гэсэн хэлбэртэй байна.

*В) Захиргааны хэргийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн гүйцэтгэх үүрэг*

Шүүхийн хэлэлцүүлгийн үед иргэдийн төлөөлөгч нотлох баримт шинжклэхэд оролцох, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих, нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах, хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар дүгнэлт гаргах, шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх, хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно.

## **8. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, санал**

Та шүүх хуралдаан дуусахаас өмнө өөрийн гэсэн санал, дүгнэлтээ гаргах ёстой. Энэ санал, дүгнэлтэд Та ямар хэрэгт оролцож байгаа болон хэргийн үйл явдлыг товчхон бичиж, хэрэг үйлдэгдэхэд хэний буруу байсан талаар бичгээр санал, дүгнэлт гаргана. Та иргэн, захирагааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцвол иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцвол иргэдийн төлөөлөгчийн санал бичнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд З хүртэл иргэдийн төлөөлөгч оролцуулахаар заасан бөгөөд энэ тохиолдолд иргэдийн төлөөлөгчид санал зөрвөл санал, дүгнэлтээ тус тусдаа гаргаж болно.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд оролцож, хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхэд оролцох ба иргэдийн төлөөлөгч Та зөвхөн олон нийтийн төлөөлөл, ил тод байдлын илэрхийлэл болохоос гадна мэргэжлийн хуульчийн хэмжээнд ёс зүйг баримтлах, хараат бус, нөлөөнд үл автах нь иргэдийн төлөөлөгчийн эрхэм зорилго мөн.

## **ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДАРАА ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

V БҮЛЭГ

### **1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн зүйл ажиллагаанд хориглох зүйл**

Шүүхийн иргэдийн төлөөлөгч Тээрх зүйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо үргэлж санаж, дагаж мөрдөх үүрэгтэй, хориглох тодорхой зүйл байдаг. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар иргэдийн төлөөлөгчийн зүйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно. Үүнд:

1. Шүүх хуралдааныг орхин явах,  
хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр  
хүрэлцэн ирэхгүй байх;

2. Шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;
3. Хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;
4. Хэргийн талаар нотлох баримт цуглуулах;
5. Өөрт нь итгэмжлэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;
6. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон талаар мэдээлэл өгөх.

## **2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйлийг зөрчсөнөөр хүлээх хариуцлага**

Шүүхийн иргэдийн төлөөлөгч таныг эрх зүйн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээр дурдсан хориглох үйлдлийг гаргасан эсэхэд Шүүхийн ерөнхий зөвлөл хяналт тавьдаг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь санаатай болон болгоомжгүй, хайхрамжгүй ямар ч шалтгааны улмаас дээр дурдсан хориглох үйлдлүүдийг гаргаж үл болно. Хэрэв шүүхийн иргэдийн төлөөлөгч өөрийн үйл ажиллагаанд хориглох үйлдэл гаргасан тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс таны цаашид иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хасах арга хэмжээ авдаг.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон, эрх зүйн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхээ хасуулах нь нэг талаас таныг хүлээсэн үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан болохыг харуулахын зэрэгцээ нөгөө талаас Монгол Улсын иргэн танд олгогдсон нэгэн онцгой эрх, бас журамт үүргээ нэр төртэй биелүүлж чадаагүй болохыг илэрхийлэх тул нэн анхааралтай, хариуцлагатай хандах нь зүйтэй.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад шалтгаанаар шүүхийн үйл ажиллагаанд оролцохоос санаатайгаар зайлсхийсэн бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохаргахэмжээавдаг болохыганхаарнаа.

## **3. Нууц хадгалах**

Шүүх хуралдаан бүр үргэлжлэх хугацааны хувьд харилцан адилгүй. Зарим шүүх хуралдаан хэдэн цагаар үргэлжлээд дуусдаг бол ээдрээ, төвөгтэй зарим хэргийн шүүх хуралдаан хэдэн өдрөөр ч үргэлжилж

болно. Шүүх хуралдааныг даргалагч шүүгч шүүхийн шийдвэр, шийтгэх, цагааттах тогтоолын агуулгыг танилцуулж, тогтоох хэсгийг уншиж сонсгосноор хаадаг.

Шүүхийн танхимд байгаа хүмүүс шүүхийн шийдвэр, шийтгэх, цагааттах, шүүхийн тогтоолыг босч сонсоно. Ийнхүү уншиж сонсгосноор шүүхийн шийдвэр, шийтгэх, цагааттах, шүүхийн тогтоол хүчинтэй болно. Хэрэв шүүх хуралдааны оролцогчдоос

шүүхийн тогтоолын агуулга хэсгээс ойлгохгүй болон тодруулах зүйл байгаа бол хуралдааныг даргалагч шүүгч шаардлагатай асуудлыг тайлбарлаж өгнө.

Даргалагч шүүгч шүүх хуралдааныг хааснаар шүүхийн иргэдийн төлөөлөгч таны гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болно.

Шүүхээр хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагаан дахь таны оролцоо дуусгавар болсон ч төр, байгууллага хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг нууцлах үүрэг тань хэвээр хадгалагдах болно.

Мөн хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шийдвэр таны сэтгэл санаа болоод хувийн үнэлэмжид заавал нийцэх албагүй харин хуульд нийцсэн байх ёстой гэдгийг анхаарна уу.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь тодорхой ял шийтгэл хүлээсэн гэм буруутай этгээдийн өмнөөс шаналах, нөхцөл байдлыг өөр дээрээ тусган авч сэтгэл зүйгээ таагүй байдалд оруулахгүй байхыг хичээх хэрэгтэй.



#### 4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн урамшуулал

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс олгох асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталсан журмаар зохицуулна.



## **ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ТАНЫ ХАРААТ БУС БАЙДАЛ**

### **1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал**

VI БҮЛЭГ

Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны хараат бус байдал гэдэг нь эрх зүйн хэрэг маргааны үйл баримт, хэргийн бодит байдлыг тогтоох, дүгнэлт гаргахдаа ямар нэг сэтгэлийн хөдлөл, хөндлөнгийн оролцоо, дарамт шахалтгүйгээр, аливаа хувийн ашиг сонирхол харахгүй байх явдлыг ойлгоно.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч таныг шүүх хуралдаанд оролцох, дүгнэлт гаргах ажиллагаанд шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон өөр бусад ямар ч этгээд аливаа хэлбэрээр нөлөөлөхийг оролдох явдлыг хуулиар хориглодог.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч танд хөндлөнгөөс хэн ч, ямар ч хэлбэрээр нөлөөлөх эрхгүй болохыг сайтар ухамсарлаж, өөрийн хараат бус байдлаа хамгаалах, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх чадвартай байх нь чухал юм.

### **2. Таны шүүхийн иргэдийн төлөөлөгчийн ажил үүрэгтэй холбогдуулан хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдвол Та яах ёстой вэ?**

Шүүхийн иргэдийн төлөөлөгч өөрт нь хөндлөнгийн нөлөө үзүүлэх гэсэн аливаа оролдлогыг сортогоор мэдрэх чадвартай байх учиртай. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх дараах нийтлэг оролдлого гарч болох юм.



Шүүхийн иргэдийн төлөөлөгч танд дээрх болон өөр бусад хэлбэрээр хөндлөнгөөс нөлөө үзүүлэх, таны хараат бус байдалд халдах аливаа оролдлого мэдэгдсэн буюу илэрсэн тохиолдолд энэ тухай Шүүхийн тамгын газрын ажилтанд яаралтай мэдэгдэж, шүүгчийн нэгэн адил нөлөөллийн мэдүүлэг бөглөнө.

Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөх ямар нэгэн оролдлого гарсан тохиолдолд Та тухайн нөлөөлөх оролдлого гаргасан этгээдээс айж эмээх, сүрдэх, түүнээс болоод энэ тухай Шүүхийн тамгын газарт мэдээлэхгүй нуун дарагдуулах, нөлөөллийн мэдүүлэг бөглөхөөс татгалзаж болохгүй. Учир нь энэ тухай нуун дарагдуулах нь хожим илүү ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй ба харин нэн даруй мэдээлж, нөлөөллийн мэдүүлэг бөглөсөн байдал тань таныг хараат бус ажилласан, гадны нөлөөнд автаагүй болохыг харуулна (Нөлөөллийн мэдүүлгийн загварыг хавсралтаас харна уу.).

Шүүхийн иргэдийн төлөөлөгч таны хараат бус байдалд халдсан этгээдэд Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн холбогдох шүүхээс тодорхой хариуцлага хүлээлгэдэг.

## ХАВСРАЛТ

### Эрүүгийн шүүх хуралдаанд оролцож буй иргэдийн төлөөлөгчийн санал

20...оны ... сарын ....-ны өдөр

.....хот/сум

..... шүүхийн .....  
шүүгчийн даргалсан .....-д холбогдох  
эрүүгийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр  
оролцов.

Хэргийн талаар:

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Гэм буруутай эсэх:

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Санал гаргасан

